



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/751

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд малын чанар, үүлдэр угсааг сайжруулах зорилгоор нийлүүлэгдсэн өсвөр хээлтүүлэгчийг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгаарлан маллаж байгаатай холбогдон гарч буй зардалд 1 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 1 000 000 төгрөг /нэг сая/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ